



**МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2020 оны 06 сарын 15 өдөр

Дугаар A/321

Ховд

Г Ажлын хэсэг байгуулах тухай Г

Ургамал хамгааллын тухай Монгол Улсын хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтыг үндэслэн, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээг хэрэгжүүлэх зорилгоор **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Царцаатай тэмцэх ажлыг зохион байгуулан, гүйцэтгэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

дарга:

Б.Бямбажав

- Аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын дарга

Гишүүд:

Ц.Пүрэвсүрэн

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Ж.Болормаа

- Аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын нягтлан бодогч

Засаг дарга нар

- Мөст, Мөнххайрхан, Манхан, Зэрэг, Цэцэг, Дуут

Нарийн бичгийн

дарга:

М.Цогт-Эрдэнэ

- Хүнс, Хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн

2. Тэмцэх талбай, хорны хуваарилалтыг хавсралтаар баталсугай.


3. Царцаатай тэмцэх ажилд шаардагдах хүн хүч, машин техникийн бэлэн байдлыг ханган, тэмцэх ажиллагааг 06 дугаар сарын 15-наас эхлэн 07 дугаар сарын 09-ийг дуусталх 25 хоногийн хугацаанд шуурхай зохион байгуулж, холбогдох бичиг баримтыг бүрэн бүрдүүлэн, ажлын гүйцэтгэлийн тайланг 2020 оны 07 дугаар сар 18-ны дотор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт ирүүлэхийг сумдын Засаг дарга наарт үүрэг болгосугай.

02 61413

4. Царцааны хор цацсан бэлчээрийн талбайг 14 хоногийн хугацаанд чөлөөлж, хүн мал нэвтрүүлэхгүйгээр хорио цээрийн арга хэмжээ авч ажиллахыг сумдын болон багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Царцаатай тэмцэх ажлын явцад байнгын хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллахыг Мэргэжлийн хяналтын газрын дарга /П.Эрдэнэчулуун/, ажлын гүйцэтгэлээр гарсан зардлыг хянан баталгаажуулж, гүйцэтгэлийн тайланг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулан Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яаманд хугацаанд нь хүргүүлж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Хүнс, Хөдөө аж ахуйн газрын дарга /Б.Бямбажав/ нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2020 оны
06 дугаар сарын 15-ны өдрийн
А/321 Дүгээр захирамжийн хавсралт

ЦАРЦААТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН НЭР, ТАЛБАЙН ХУВААРИЛАЛТ

№	Сумдын нэр	Газрын нэр	Бэлчээрийн талбай /га/	Голомт /мян.га/	Тэмцэх талбай /га/
1	Манхан	Ботгон багийн Хавчигийн Цагаан хөтөл, Ангиртын бэлчир, Замын цахир, Үнэгтийн үзүүр	358350.73	45.0	3000
2	Цэцэг	Баян овоо баг Дээд овоо, Доод овоо, Хонгорын шил, Намын уулс, Шаврын гол	255303.40	55.0	3000
3	Зэрэг	Цагаан бургас багийн Цагаан бургасны ам, Ганц модны гол, Бурхадын гол, Бургасан багийн үрд адuu гаргадаг, Хэрээ хүжир, Тойны эх	247562.0	40.0	3500
4	Мөст	Давст багийн Гэгээн хөтлийн гүү, Тавтын Эхэн, Дунд, Адаг ус, Баянхайрхан	387725.0	58.0	3500
5	Мөнххайрхан	Цэнхэр багийн Ендэргт, Дээд, Доод улаан говь, Борт багийн Их тошин, Бага тошин, Алаг багийн Хөх сайр	167816.10	80.0	3500
6	Дуут	Улаан говь, Цахируу, Хар гэр, Чагаан гэр, Мушгуй, Ялаат булаг, Шагдарын булаг, Архужирт, Шар хөтөл, Ишгэн толгой, Гурван салаа	212206.58	35.0	3500
	Дүн		2154769.29	278.9.0	20000

--Оо--